

ТОВЬЁГ

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
I.1. Төслийн талаарх мэдээлэл.....	2
I.2. Төслийн талбайн байршил	2
I.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл	3
I.4. Уурхайн ажлын горим.....	3
I.5. Уурхайн хүчин чадал	3
I.6. Үйлдвэрлэлийн нөөц	4
I.7. Уулын ажлын өрнөл дараалал, календарчилсан төлөвлөгөө	4
I.8. Дэд бүтэц.....	6
БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ	7
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
III.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
III.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	11
III.3. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	12
БҮЛЭГ IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	12
IV.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
IV.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
IV.3. Осол эрсдэлийн төлөвлөгөө.....	15
IV.4. Тэр бум мод үндэсний хөтөлбөр	17
IV.5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	17
IV.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
IV.7. Хатуу хог хаягдлын менежмент	17
IV.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	18
IV.9. Байгалийн гамшгаас үүсэж болзошгүй ослын менежментийн төлөвлөгөө	22
БҮЛЭГ V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт№. 1 Талбайн солбицолууд.....	2
Хүснэгт№. 2 Уурхайн ажиллах горим	3
Хүснэгт№. 3 Зарцуулах усны хэмжээ	6
Хүснэгт№. 4 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	11
Хүснэгт№. 5 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал	12
Хүснэгт№. 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүний зардал	13
Хүснэгт№. 7 Осол эрсдэлийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт№. 8 Ойжуулалтын зардал.....	17
Хүснэгт№. 9 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт№. 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
Хүснэгт№. 11 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 Төслийн талбайн байршил.....	2
---	---

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1. Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр: Эмээлт уул барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Билэгт гүнж” ХХК, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011421116, регистрийн дугаар: 5747139

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар, Баянзүрх, 1-р хороо, 12 хороолол, 102 тоот Утас1: 96989999, Утас2:

Тусгай зөвшөөрөл: 20/М024


Талбайн хэмжээ: 108 га

I.2. Төслийн талбайн байршил

Эмээлт уул барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт дэвсгэрт оршино. Улаанбаатар хотоос баруун зүгт 30 км, Шувуун фабрикаас 13 км-т Сонгино- Хайрхан уулын баруун үзүүрийн намхан толгодлог хэсэгт байрлана. Байр зүйн зургийн L-48-10 хавгайд оршино.



Төсөл хэрэгжих талбайн байршил



Зураг №. 1 Төслийн талбайн байршил

Хүснэгт№. 1 Талбайн солбицолууд

№	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ
1	106° 32' 12.47" E	47° 53' 10.57" N	108.0 га
2	106° 32' 12.47" E	47° 53' 44.05" N	
3	106° 33' 02.82" E	47° 53' 44.05" N	
4	106° 33' 02.82" E	47° 53' 10.57" N	

I.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэр Эмээлт уул нэртэй газарт орших 108.0 гектар талбайг хамарсан түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал олборлохыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011421116 тоот 20/МО24 дугаар бүхий тусгай зөвшөөрлийг 2035 оны 10 сарын 22-ны өдрийг дуустал хугацаагаар олгосон байна.

I.4. Уурхайн ажлын горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 06 сараас 09 сарыг дуустал буюу 4 сарын хугацаанд ил уурхай өдөрт 12 цагийн 1 ээлжээр ажиллана. Уурхайн жилд ажиллах хоног 122 хоног ажиллана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон бутлах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт №. 2 Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	122.0
2	Баяр ёслол	хоног	4.0
3	Амралт, засвар үйлчилгээ	хоног	5.0
4	Бэлтгэл ажлын хоног	хоног	3.0
5	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	2.0
6	Цаг агаарын саатал	хоног	1.0
7	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	107.0
8	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12.0
9	Ээлжийн тоо	ш	1.0
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12.0
11	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх), цаг	цаг	1.0
12	Ээлжийн бэлтгэл, төгсгөл, цаг	цаг	0.5
13	Өдрийн сул зогсолт	цаг	0.5
14	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	10.0
15	Цаг ашиглалт		0.83
16	Жилд ажиллах нийт цаг	цаг	1284

I.5. Уурхайн хүчин чадал

“Эмээлт уул” барилгын чулууны ордоос жилдээ 100.0 мян.м³ барилгын чулуу олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөв. Нийт үйлдвэрлэлийн нөөц 1973.54 мян.м³ байна. Төслийн хүчин чадал зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч байна.

Ашиглах хугацаа: Ил уурхайн нийт ажиллах жилийг дараах байдлаар тодорхойлно. $T = Q_a / A_r$; жил Үүнд:

Q_a –Үйлдвэрлэлийн нөөц, мян.м³

A_r –Уурхайн жилийн хүчин чадал, мян.м³

“Эмээлт уул” барилгын чулууны ордын хувьд ил уурхайн хүчин чадал $T = 1973.54$ мян.м³/100.0 мян.м³ = 19.74 ≈ 20 жил байна.

I.6. Үйлдвэрлэлийн нөөц

Ашиглалтын нөөцийн тооцоо: Ашиглалтын нөөц нь ил уурхайн хүрээнд өртөж байгаа ашиглах боломжтой геологийн нөөцийг хэлнэ. “Эмээлт уул” барилгын чулууны ордын хувьд бодитой В нөөцөд тулгуурлан боломжтой С нөөцийг уурхайн ашиглалтын явцад өртүүлэн олборлохоор төлөвлөлт хийсэн.

“Эмээлт уул” барилгын чулууны ордын ЭБМЗ-өөр батлагдсан нөөц нь бодитой В зэрэглэлээр 1.99 сая.м³ буюу 5.82 сая.тн, боломжтой С зэрэглэлээр 2.72 сая.м³ буюу 7.24 сая.тн, нийт 4.7 сая.м³ буюу 13.06 сая.тн барилгын чулууны нөөц үүнээс ил уурхайн хүрээнд ашиглалтын нөөцөөр 1983.45 мян.м³ барилгын чулууны нөөц өртөж байна. Ил уурхайн хүрээний гадна 2737.47 мян.м³ барилгын чулууны нөөц үлдэж байна.

Ил уурхайн хүрээнд барилгын чулуу 1983.45 мян.м³ буюу 5275.99 мян.тн, нийт хөрс 599.68 мян.м³, уулын цулын нийт эзлэхүүн 2583.13 мян.м³ байна.

Уурхайн хаягдлын тооцоо: Ашиглалтын үеийн технологийн хаягдлыг 1.9%-иар тооцоолсон. Энэ хаягдалд ухаж ачих үеийн болон түрэх үеийн хаягдал байна гэж үзсэн. Барилгын чулууны ордын хувьд хаягдлын хувийг хамгийн багаар тооцоолсон.

Уурхайн бохирдлын тооцоо: Уурхайн бохирдлыг тооцохдоо ул болон таазнаас 0.1 м-р хөрсөөр буюу 1.4% бохирдоно гэж тооцсон.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо: Ил уурхайн хүрээнд өртөх ашиглалтын геологийн нөөцөөс хаягдах барилгын чулууг хасаж, үлдэгдэл нөөц дээрээ бохирдлоор орж ирэх хөрсийг нэмж үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийлээ. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийхдээ уурхайн блок тус бүр дээр тооцож гаргасан. Үйлдвэрлэлийн нөөцийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд үзүүлээ.

Ордын хэмжээнд үйлдвэрлэлийн нөөц 1973.54 мян.м³ буюу 5249.61 мян.тн барилгын чулуу байна. Уурхайн нийт хуулах хөрсний хэмжээ 599.68 мян.м³ байна. Хөрс хуулалтын коэффициент 0.12 м³/тн байна.

I.7. Уулын ажлын өрнөл дараалал, календарчилсан төлөвлөгөө

“Эмээлт уул” барилгын чулууны ордын В-IV блокоос эхэлж олборлохоор төлөвлөв. Уулын ажлыг явуулахдаа хөрс хуулалт болон барилгын чулуу олборлолтын ажлыг жигд байхаар төлөвлөсөн.

Хөрс хуулалтын явцад хуулсан хөрсийг зам талбайн ажилд хэрэглэн процессуудын хоорондын уялдаа холбоог уян хатан байлгах боломжийг бий болгож байгаа юм.

Ордын хөрсний зузаан 2-3 м, барилгын чулууны зузаан 28-46 м байгаа тул уурхайн доголын өндөр дунджаар 5 м орчим байхаар байна. Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангахын тулд уурхайн хажуугийн өнцгийг 65-70 градусаас ихгүй налуутай байгуулна.

Хөрс хуулалт болон олборлолтын ажлын зохион байгуулалт болон уулын ажлын өрнөл дарааллыг ашиглалтын жил бүрээр дараах байдлаар харуулав.

Ашиглалтын жил	Блокийн дугаар	Барилгын чулуу		Хөрс		Хөрс хуулалтын коэффициент м3/тн
		мян.м ³	мян.тн	мян.м ³	мян.тн	
1-р жил	B-IV	74.3	197.7	30.20	69.46	0.12
	C-VII	11.9	31.7			
	C-VIII	3.5	9.3			
	C-X	5.6	15.0			
	/B+C/ нөөц	95.4	253.7			
2-р жил	B-IV	94.3	250.7	32.60	74.98	0.11
	C-VII	18.9	50.3			
	/B+C/ нөөц	113.2	301.0			
3-р жил	B-IV	95.7	254.6	33.60	77.28	0.12
	C-VII	8.0	21.4			
	/B+C/ нөөц	103.7	275.9			
4-р жил	B-IV	104.6	278.1	33.82	77.79	0.12
	C-VII	4.1	11.0			
	C-VIII	0.3	0.9			
	/B+C/ нөөц	109.0	290.0			
5-р жил	B-III	38.3	101.8	33.15	76.25	0.11
	B-IV	66.9	177.9			
	C-VI	0.9	2.3			
	C-VII	5.6	15.0			
	C-VIII	0.8	2.0			
	/B+C/ нөөц	112.4	299.1			
6-10-р жил	B-II	1.7	4.6	163.37	375.75	0.12
	B-III	477.5	1270.1			
	B-IV	2.3	6.1			
	C-V	10.7	28.5			
	C-VI	8.2	21.9			
	C-VII	0.6	1.5			
	C-VIII	0.1	0.2			
	/B+C/ нөөц	501.1	1332.8			
11-20 жил	B-I	455.0	1210.4	272.9	627.75	0.11
	B-II	360.3	958.5			
	B-III	38.4	102.1			
	C-I	15.6	41.5			
	C-II	5.3	14.2			
	C-III	16.6	44.2			
	C-IV	1.1	2.9			
	C-V	4.8	12.7			
	C-VI	2.5	6.7			
	C-IX	39.0	103.8			
	/B+C/ нөөц	938.7	2497.0			
Нийт дүн		1973.54	5249.61	599.68	1379.25	0.11

Ашиглалтын жил тус бүр 100.0 мян.м³ барилгын чулуу олборлож жил тус бүр хуулах хөрсний хэмжээг харуулав. Нийт 20 жил ажиллаж 1973.54 мян.м³ барилгын чулуу олборлож 599.68 мян.м³ хөрс хуулна.

I.8. Дэд бүтэц

Цахилгаан хангамж: “Эмээл Уул” ХХК нь уурхайн хойд хэсэгт байрлах 35 кВ-ын дэд станцаас бууруулж 10/0.4 кВ-ын 1 км урт ЦДАШ татна.

Усан хангамж: Усны үндсэн хэрэглэгч нь уурхайн тосгон, замын усалгааны ажил зэрэг байна. Ундны болон техникийн усыг 1.5-2.5 л/сек ундаргатай гүний худгаас зөөвөрлөж гүйцэтгэнэ. Ашиглалтын хугацаанд нийт 37 хүн байна.

Хүснэгт №. 3 Зарцуулах усны хэмжээ

№	Төслийн жил	Ил уурхайн хэрэглээ, мян.м³/жил	Хотхоны хэрэглээ, мян.м³/жил	Уурхайн нийт хэрэглээнд мян.м³/жил
1	1-р жил	1.61	0.20	1.80
2	2-р жил	1.61	0.20	1.80
3	3-р жил	1.61	0.20	1.80
4	4-р жил	1.61	0.20	1.80
5	5-р жил	1.61	0.20	1.80
6	6-10-р жил	8.03	0.99	9.01
7	11-20-р жил	16.05	1.98	18.03
Нийт		32.10	3.96	36.06

Ордын гидрогеологийн нөхцөл: Эмээлт уул орд нь А.Н.Маринов, Н.В.Попов нарын болон бусад судлаачдын 1933-1960 он хүртэлх хийсэн региональ гидрогеологийн судалгаагаар Хангай-Хэнтийн гидрогеологийн мужийн төв хэсэгт багтана. Энэ дүүрэгт гидрогеологийн бие даасан төрөлжсөн судалгаанууд нэлээд эрчимтэй хийгдсэн байна. Ялангуяа Туул голын хөндийн аллювиаль хурдаст, мөн Туул голын зүүн баруун цутгал болох Сэлбэ, Яргайт, Бөхөг, Түргэний голын хөндийнүүдэд олон арван гидрогеологийн цооногууд өрөмдөж усан дээж авч шинжилгээ, судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг. Дээрх ажлууд нь янз бүрийн судалгааны үе шат, цаг хугацаанд хийгдсэн. Уг судалгааны ажил нь Улаанбаатар хотын барилга байгууламж, үйлдвэрүүд, хотын хүн амын усан хангамжийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн байна. Судалгааны ажлыг тэр үеийн ЗХУ-ын эрдэмтэн судлаачид болох Л.Н.Аристов, А.Т.Бобрышев, Б.А.Воротников, Д.С.Грузорев, К.И.Гоманько, В.Н.Попов нар голлон хийсэн байна.

Тус дүүрэг нь гадаргуугийн ус элбэгтэй бөгөөд ихэвчлэн хөрсний ус тархсан байдаг. 1980 оны дундуур тус дүүрэгт эрэл-геофизикийн цогцолбор экспедицээс 1:50000-ний зураглалын ажлын үед гидрогеологийн судалгааг Т.Сэнгэдорж, Б.Банзрагч, О.Гомбобаатар нар олон арван цооног өрөмдөж гидро-химийн дээж авч судалсан байна. Ордын дүүргийн уст давхаргыг геологийн тогтоц, гадаргуугийн геоморфологийн хэлбэр, ус хуримтлалын нөхцөл, байршил, унах хур тунадасны хэмжээнээс хамааралтайгаар тогтцоор нь дараах уст давхаргад ялгасан байдаг.

- Голоцены үеийн аллюви-пролювийн уст үе
- -Плейстоцен-Голоцены пролюви-делювийн уст үе
- -Плиоцены хурдасны уст комплекс

Эдгээрээс ордын хувьд голлох уст бүрдэл нь Голоцены үеийн уст давхарга бөгөөд ордын талбайн дүүргээр урсан өнгөрөх Туул гол тэдгээрийн хөндий, том, жижиг амнуудад тохиолдоно. Газрын доорх энэ уст давхарга нь чөлөөт гадаргуудтай

байдаг тул ихэвчлэн байнгын болон түр зуурын урсгалтай гол горхи, булаг, шанд байдлаар гадаргууд нь илэрч гарсан байдаг. Эмээлт уул талбайн барилгын чулууны ордын хайгуулын явцад 40 м хүртэл өрөмдөхөд уст давхарга илрээгүй болно. Дайрга чулууны ордын ойролцоох талбайнуудад хийсэн судалгаагаар цөөн тооны бага гүний өрөмдмөл ба гар худаг, булаг байдаг нь тогтоогдсон юм. Уг өрөмдмөл ба гар худаг, булаг нь лицензийн талбайн гадна байрлах ба химийн найрлагаараа унд ахуйн усны хэрэглээний шаардлагыг хангах боловч ундарга нь харьцангуй бага юм. Иймд Дээрх булаг, шанд, өрөмдмөл ба гар худгийн усаар зөвхөн унд ахуйн усны хэрэглээг хангаж болох юм.

Өмнөх судлаачдын хийсэн судалгаанаас авч үзвэл тус дүүрэгт тархсан аллювиаль, делювиаль-пролювиаль, тунамал-хувирмал, бялхмал чулуулаг дахь уст бүрдлүүд нь ордоос хол биш зайнд орших тул карьер нээж олборлолт явуулах болон цаашид бетон зуурмагийн үйлдвэр байгуулан ажиллах тохиолдолд үйлдвэрлэлийн усны хэрэгцээг дээрх уст бүрдлүүдэд усны хайгуул судалгаа хийж ашиглах боломжтой. Дайрга чулууны ордын дүүрэгт мөнх цэвдэгшил алаг цоог тархалттай боловч ордод хийсэн уул өрөмдлөгийн ажлаар мөнх цэвдэгшил тогтоогдоогүй ба зөвхөн улирлын чанартай хөлдөлт тохиолдоно. Энэ нь 2-3 м-ийн гүнд хүрэх ба 10-р сарын 20-ноос эхлэн хөлдөж 5-р сарын 20 гэхэд бүрэн гэсэж дуусдаг. Ордын ашигт давхарга болох элсэн чулуу нь 0-5 м-т нэлээд өгөршилд орсон байна. Г.Сэнгэдорж, Б.Банзрагч, О.Гомбобаатар нарын хийсэн судалгаагаар тус дүүрэгт тархсан Q-C-ийн хурдас дахь ус нь 4-15 л/сек-ийн ундаргатай 2,0-5,0 м-ийн түвшин бууралтын хэлбэлзэлтэй, 0,2-0,5 г/л эрдэсжилттэй, химийн агуулгын хувьд гидро карбонат-натри, кальцийн төрлийн ус болох нь тогтоогдсон байна.

БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Уур амьсгал: Судалгааны талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн нь 1-р сард -38°C , дулаан нь 7-р сард $+33^{\circ}\text{C}$ хүрнэ. Жилд унах тунадасны дундаж хэмжээ 230-350 мм-с хэтрэхгүй, түүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 30-15% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг. Салхины хурд өвөлдөө 5-9 м/сек, зун 3-4 м/сек, хавартаа хааяа 10-15 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг. Цэвдэгшлэлийн мужлалаар алаг цоог тархалттай бүс нутагт хамаарах боловч лицензийн талбайд цэвдэгшил ажиглагдаагүй. Өвөлдөө хөрсний хөлдөлтийн гүн дунджаар 2,0-3,0 м-т хүрдэг.

Уул зүйн байрлал: Ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харьяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэл хэрчигдэлд нэлээд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Талбайн хойт, баруун хойт хэсгээр жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг. Хамгийн өндөр цэг нь Эмээлт уул (1347 м). Гадаргуугийн байршил илэрцийн хувьд сайн төлөв байдалтай.

Дүүргийн геологийн тогтоц: Алаг толгойгийн нүүрсний ордын районд доод пермийн бялхмал хурдас, дээд юрагийн тунамал хурдас, дээд юра-доод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал-тунамал хурдас, доод цэрдийн туфоген-тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.

Доод цэрдийн чулуу агуулагч тунамал хурдас нь хагарлын ан цаваар бялхаж гарсан хүчиллэг найрлагатай вулканитын урсцаар нийцлэгээр хучигдана. Хуучилга хурдас болж байгаа вулканитууд нь риолит, риодацит, дацит тэдгээрийн туф болон туф брекчээс бүрдэнэ.

Вулканит биетүүдийн тархац харьцангуй хязгаарлагдмал зарим талбайд тухайлбал: 154-р цооногт 6.8 м, 202-р цооногт 26.8 м, 301-р цооногт 18.8 м зузаантай тогтоогдсон байдаг. Энэ нь тухайн бялхалт явагдах үед хамгийн нам доор хотос хонхор байсантай холбоотой. Харин тухайн үедээ нэлээн өндөрлөг толгод, гүдэн байсан газруудад вулканитын урсац тархаагүй бололтой.

Дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдсыг гарал үүслээр нь дараах төрлүүдэд хуваадаг. Үүнд:

- Элюви – делювийн хурдас
- Делюви –пролювийн хурдас
- Алювийн хурдас

Хөрсөн бүрхэвч: Эмээлт уулын барилгын чулууны орд орчимд Цайвар хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах сайргархаг элсэнцэр Цайвар хүрэн болон элсэн хучаастай мараалаг Цайвар хүрэн гэсэн 2 төрлийн хөрс зонхилон тархсан байна.

Гадаргын ус: Монгол орны гадаргын ус бүрэлдэхэд бороо, цас, мөс, гүний ус оролцох боловч байгалийн газарзүйн онцлогоос шалтгаалан тэдгээрийн эзлэх хувь хэмжээ газар бүрд харилцан адилгүй байна (З.Санжмятав, 2007). Монгол орны голууд Хойд мөсөн далайн ай сав, Номхон далайн ай сав, Төв Азийн гадагш урсгалгүй ай сав гэсэн гурван ай савд багтдаг бөгөөд Улаанбаатар хот нь Хойт мөсөн далайн ай савд багтдаг Усны сав газрын ангиллаар Туул голын сав газарт багтана. Олон жилийн дундаж урсац нь 100 м-ээс илүү бүс нутагт хамаарна. Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрээр байнгын урсгалтай Туул гол урсдаг бөгөөд “Эмээлт уул” барилгын чулууны орд нь Туул голын баруун хойд зүгт 13 км орчим зайд байрладаг.

“Эмээлт уул” барилгын чулууны ордын усны үндсэн хэрэглэгч нь уурхайн тосгон, замын усалгааны ажил зэрэг байна. Ундны болон техникийн усыг 1.5-2.5 л/сек ундаргатай гүний худгаас зөөвөрлөж гүйцэтгэнэ.

Амьтны аймаг: Монгол орны амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүний үүсэл, хөгжилт, тархалтад тус орны хотгор гүдгэр, уур амьсгалын нөхцөл, ургамал нөмрөг ихээхэн нөлөө үзүүлжээ. Амьтдын тэжээл ургамлын аймгийн бүрэлдэхүүнтэй нягт холбоотой учраас байгалийн бүс бүслүүрийг дагаж нэг бүс, бүслүүрт тодорхой амьтад зонхилж байхад зарим төрлийн амьтад шилжин амьдрах нь ч бий.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Улаанбаатар хот амьтны аймгийн газарзүйн мужлалаар Умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана.

Нийслэл хотын амьтны аймаг, тэр тусмаа шувуудтай холбогдолтой мэдээ баримтууд 470-аад оноос эхлэн Н.М.Прежвальский (1946), В.Л.Бианки (1915), Е.В.Козлова (1930),

А.Я.Тугаринов (1932), W.Grumbt (1960), О.Шагдарсүрэн (1960, 1983), Н.Даваа (1963),

Г.П.Дементьев (1966), А.Болд (1960, 1968, 1977, 1986, 1990), R.Piechockii (1972,1982),

G.Kleinstaubert, W.Succow (1978), A.Kitson (1978), G.Mauesberger (1980,1982), Х.Мөнхбаяр

(1988), Ш.Болдбаатар (1997, 1999, 2002), L.Stephan (1988), Н.Цэвээнмядаг (1992), П.Цэнгэг (1994) нар өөрсдийн бүтээлдээ тусгасан байна. Эдгээр бүх хэвлэлийн мэдээ, судалгаануудын тайлан, өгүүлүүдийг профессор Ш.Болдбаатар (1997) нэгтгэн дүгнэж Улаанбаатар хотод 30 зүйл сүүгээр бойжигч хөхтөн амьтад, 14 баг, 40 овог, 110 төрлийн 205 зүйл шувуутай болохыг тэмдэглэсэн. Тэдгээрээс 66 зүйл үүрлэн өндөглөдөг, 21 зүйл гаднаас ирж өвөлждөг ба эдгээр нь хотын шувуудын үндсэн цөмийг бүрдүүлнэ. Нийт шувуудын 138 зүйл нь нүүдлийн, 66 зүйл нь суурин амьдралтай боловч суурин зүйлүүдээс хотын төвд байнга тохиолдох шувуу 39.4 хувийг эзэлнэ.

Хот орчмын нутаг нь ус намаг, ой, ойт хээр, хээрийн гэсэн байгалийн хэд хэдэн үндсэн биотопуудтай, мөн хот суурин газрын гэр хороолол, өндөр барилга, үйлдвэрийн газрууд, зуслан, хогийн цэгүүд зэрэг экологийн бичил орчнууд нь олон зүйл амьтад орж ирж нутагших нөхцөлийг бүрдүүлдэг. Их хотын чимээ шуугиан, хүн, авто хөсөг, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан амьтад нэг газар байнга оршин амьдардаггүй улирлын чанартай нүүдэллэн шилждэг онцлогтой.

Ойн зах, хад асрат уулс ам хөндийгөөр чоно (*Canis lupus*), үнэг (*Vulpes Vulpes*), хярс (*Vulpes corsac*), зэрэг махчин идэштэн, бор гөрөөс (*Capreolus pygargus*), буга (*Cervus elaphus*) зэрэг салаа туурайтан, туулай (*Lepus tolai*), дагуур огдой (*Ochotono dauurica*), зэрэг туулай хэлбэртэн, хэрэм, зурам (*Spermophilus undulatus*), хулгана (*Apodemus peninsulae*), үхэр огодой (*Ochotono dauurica*) зэрэг мэрэгч амьдарна.

Ийнхүү тус нутагт амьтан ургамлын аймгийн экосистемийн шинж төрх алдагдаж энэ хавийн амьтны зүйлийн бүрдэлд хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд голлох болжээ. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.

Ургамлын нөмрөг: “Эмээлт уул” барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт байрлана. Монгол орны урамал зүйн мужлалаар Азийн цөлийн мужийн Алашаа говийн тойрогт хамаарагдаж байна /Юнатов/. Энэ бүс нутагт жилдээ 100 мм–ээс бага хур тунадас унадаг, хуурай, халуун зун болдог, ургамал ургах дулаан хоногийн тоо их боловч хангалттай чийг өгч чаддаггүй учир өвслөг ургамлаас илүү сөөг, сөөгөнцөр ургамлууд зонхилон тохиолддог байна. Алашаа говийн тойргийн ургамалжилтын гол онцлог нь унаган /индемик/ ургамлын төрөл зүйл бусад тойргуудаас олон зүйл ургадгаараа ихээхэн онцлог юм. Мөн ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйл ч цөөнгүй тохиолдох онцлогтой.

“Эмээлт уул” барилгын чулууны орд ашиглах талбайн орчмоор цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилох ба хур тунадаснаас хамаардгаараа өвөрмөц байдаг. Өвслөг ургамлууд нь тухайн газрын 35%-ийг бүрхдэг.

Их нарт дахь онцлог зүйлүүдэд алтлаг холтсоороо нэшсэн тарваган харгана (*Caragana pugnata*) болон хээрийн бариулт бүйлс (*Amygdalus pedunculata*), Ямаан харгана (*Caragana pugnata*) орно. Бариулт бүйлс нь үрээр нь хооллогч мэрэгч амьтад болон навч мөчрийг нь иддэг туруутан амьтдын тэжээлийн чухал эх үүсвэр болдог.

Дэд бүтэц, нийгэм эдийн засгийн байдал: Сонгинохайрхан дүүрэг 120,1 га нутаг дэвсгэртэй. Нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил залган оршдог. Монгол Улсын нийт хүн амын 11.6 хувь, Нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь, орон сууцны хорооллын 27.1 хувь, гэр хорооллын 72.9 хувь тус дүүрэгт байдаг. Засаг захиргааны анхан шатны нэгж 43 хороотой. Орон сууцны 12 хороо, гэр хорооллын 22 хороо, холимог 9 хороо оршдог. Нийт 335.703 хүн амтай бөгөөд 94132 өрхтэй юм. Дүүргийн газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав бүхий газар, 3 хувийг зам шугам сүлжээ, барилгажсан газар тус тус эзэлдэг. Дүүргийн хэмжээнд 83687 толгой малтай. Үүнээс тэмээ 23, үхэр 26764, адуу 13926, хонь 20917, ямаа 22057 толгой малтай байна. Сонгинохайрхан дүүрэгт нийт үйл ажиллагаа явуулж байгаа 25865 аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг.

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт №. 4 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий рельеф	Ажлын үед шинээр хөрс хуулах, уурхайлалтын ажил хийгдэх тул энэ төрлийн нөлөөлөл их гэж үзлээ.	Төслийн талбайд	Их
Цаг уур, уур амьсгал	Цаг агаарын нөхцөл байдал төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй /үер, салхи/ байдлаас төслийн ажил зогсох удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Агаарын чанар	Төслийн үйл ажиллагаа, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ.Төслийн талбайд ажиллах теаникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.	Төслийн талбайд	Бага
Хөрсөн бүрхэвч	Хөрсөн бүрхэвч бүр мөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	Талбайн ургамал бүрмөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Усан орчин	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгарагчаас ус бохирдож болзошгүй.	Төслийн талбай орчим	Бага

III.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ. Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.

III.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороон дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх

- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй

III.3. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах осолгүй ажлыг байнга хийнэ.

БҮЛЭГ IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ

Төлөвлөгөөний танилцуулга: Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулав.

Хүснэгт №. 5 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд	Нэг жилийн зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3 000.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал	2 300.0
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	3 000.0
4	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	1 500.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 720.0
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
	Нийт	11 520.0

IV.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

Хүснэгт№. 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүний зардал

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин					
Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дах/2ь тоосны хэмжээг тодорхойлж байх Бутлах цехийн үйл ажиллагаанаас гарч буй тоосжилтыг бууруулахын тулд салхины доод талд тоос баригч тор хийх	Үйл ажиллагааны турш	1 500.0	2026-2029 он	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
		Жилд 2 удаа	ОХШХ-ийн зардлаас	2026 он	
		Эхний жилд	Үйл ажиллагааны зардлаар	2026он	
Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүснэ.	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Авто машины тээвэр хийх үед	1 500.0	2026-2029 он	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5013:2003 Бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 Дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Газрын гадарга, хэвлий					
Уурхай дахь барилгын чулууг олборлож, газрын гадаргад цоо шинэ хотгор гүдгэрийн хэлбэр үүсгэнэ.	Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх	Цех ашиглалтын төгсгөлд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	2026 он	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Хөрсөн бүрхэвч					
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж,	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах, Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах Хэлбэржүүлж зассан талбайг шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэх	Эхний үе шатанд, ашиглалт дууссан талбайд тухай бүрт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	2026-2029 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”

“Эмээлт уул” дайрганы орд

элэгдэл, эвдрэлд өртөнө					
Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Ашиглалтын явцад	-	2026-2029 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Хог хаягдлаар хөрс бохирдож болзошгүй	Хог хаягдлыг, тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ариутгах, зайлуулах арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хийх	Тухай бүрт	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардлаар	2026-2029 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Ургамлан нөмрөг					
Уурхайгаас барилгын чулуу олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устгах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс хуулалтын үед, зам, карьер болон бусад газрын ашиглалт дууссаны дараа	Нөхөн сэргээлтийн зардлаар	2026-2029 он	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг
Уурхайн үйл ажиллагааны туршид тоосжилт үүсэх, энэ нь ойролцоох газрын ургамлын фотосинтезийн үйл ажиллагаанд нөлөөлөн ургалтын эрчмийг доройтуулах	Тоосжилтоос үүсэх дам нөлөөг багасгах үүднээс шаардлагагүй замуудыг хаах, усалгаа хийх, байнгын хяналт тавьж байх Мониторинг хийх газруудыг барьж байгуулах, үйл ажиллагаа эхлэх үед оновчтой сонгон нөлөөллийг хэрхэн бууруулах арга замыг боловсруулан шууд хэрэгжүүлж байх	Тухайн үед	Мониторинг гийн зардлаар	2026-2029 он	ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага 2 000 000
	Уурхайн гол зам дагуу модлог ургамал тарьж, тоосны тархацыг бууруулах	Ашиглалтын явцад	Дүйцүүлэн хамгааллын зардлаар	2026-2029 он	
Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн БОУАӨЯ-аас заасан талбайд мод тарих	Сонгинохайрхан дүүргийн БОУАӨЯ-тай хамтран сонгосон талбайд	Уурхайн зардлаар	Төсөл хэрэгжих явцад	
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн			3 000.0		

IV.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Эмээлт уул ” барилгын чулууны орд нь 2026 оны 4-9 сар хүртэл уулын дайрга бутлах бутлуурын үйлдвэр угсралтын ажил хийгдэж байна. 2026 оны 9 сараас эхлэн уулын дайрга олборлож эхлэх бөгөөд эхний жил буюу 2026 онд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхээгүй байна. Харин 2 дах жилээс орон нутгийн байгууллагаас санал авж дүйцүүлэн хамгаалах болон уурхайн кэмп орчимд биологийн нөхөн сэргээлт хийж ажиллахаар төлөвлөж байна.

IV.3. Осол эрсдэлийн төлөвлөгөө

Хүснэгт№. 7 Осол эрсдэлийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
Галын аюул, гамшиг, осол аюул	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458 : 2014 стандартад заасан химийн бодисын агуулахын холбогдох бүх шаардлагыг барилгын зураг төсөл, тогтмол үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж стандартыг мөрдөж ажиллах	Барилгын зураг төсөл ба үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд			Үйл ажиллагааны эхний жилд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Гал гарах үед анхааруулгы н самбар объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566 2005
	Агуулахын байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт) галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих / Галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулгын самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл..., /	Объектын доторх ашигтай талбайгаас хамаарч 80м2 ихгүй талбайд тус бүр 1ш галын хор 40.0 байршуулах Эхний байдлаар 3-5 ш хор	10.0 хор + 5 иж бүрдэл		Жилд нэг удаа	
	Байгууламжийн барилгын ажлыг бүрэн хүлээлцсэний дараа галын аюулгүй байдлын дүгнэлт, гэрчилгээг холбогдох мэргэжлийн албаар гаргуулж тухайн дүгнэлтийн дагуу гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх	Галын дүгнэлт, зөвшөөрөл	200		Үйл ажиллагааны эхний жилд	Галын аюулгүй байдлын тухай хууль

Шаардлагатай тохиолдолд галын эсрэг төхөөрөмж нэмэлтээр суурилуулж, галын хорын тоог нэмэгдүүлэх, гэнэтийн осол аюулын үед ашиглах хамгаалах хэрэгслийг (амьсгалын баг гэх мэт) байршуулах		Гүйцэтгэлээр төсөвлөнө			Гамшгаас хамгаалах тухай хууль
Ажилчдын тосгон, гал тогоонд галаас сэргийлэх арга хэмжээ, заавар зөвлөмжийг байнга өгч байх				Байнга	
ТМА-ын үйл ажиллагааны явцад галын аюул, гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Жишиг тариф 1000.0 Гэрээгээр тохиролцсон төсвөөр			Гамшгаас хамгаалах тухай хууль
Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж өөрийн ОБХТ–д (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	200		Ашиглалтын хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах		150.0*3=450.0		ашиглалтын хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах Аюултай болон хортой бодис, материалыг хадгалалт, ашиглалтын үед аюулгүй ажиллагааны болон осол аваарын үед авах арга хэмжээний дарааллыг тогтоож, түүнийг мөрдөж ажиллах	Зохион байгуулах	150.0*3=450.0			Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
Нийт		2300			

IV.4. Тэр бум мод үндэсний хөтөлбөр

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаарт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” хөтөлбөрийг тусгав.

Хүснэгт №. 8 Ойжуулалтын зардал

№	Зардлын утга	Нэгж	Талбайн хэмжээ	Тоо, ш	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Навчит модны суулгацаар ойжуулах	га	0.5	500	1 500 000	3 000 000
2	Навчит модны суулгацаар ойжуулсан талбайн арчилгаа				1 500 000	

IV.5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн төсөл хэрэгжих явцад газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

IV.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Эмээлт уул” барилгын чулууны орд төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

IV.7. Хатуу хог хаягдлын менежмент

“Эмээлт уул” барилгын чулууны орд нь ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ялган төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хаяна.

- Техникийн хувьд бүрэн бус, гэмтэлтэй тээврийн хэрэгслийг цаг тухайд нь засвар, үйлчилгээнд оруулж байх, хэрэв хөрс шатах, тослох материалаар бохирдсон бол тухай бүрд нь зохих стандартын дагуу ариутгаж, цэвэрлэх,
- Уурхайд ашиглагддаг түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүнийг зөөх, тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зааврын талаар сургалт явуулах, гарын авлагыг бодис тус бүр дээр бэлтгэн тараах, санамж сэрэмжлүүлэг бүхий мэдээллийн самбарыг шаардлагатай газруудад байрлуулах, дотоод дэг журмыг нарийн чанд мөрдүүлэх
- Хатуу хог хаягдлыг хадгалах цэг байгуулан түүнд төвлөрүүлэн хаяж байх, Хатуу хог хаягдлын цэг нь зориулалтын тагтай, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой. Хураагдсан хог хаягдлыг тодорхой давтамжтайгаар төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэн хаяж байх.
- Хатуу хог хаягдлыг зориулалтын сав, баглаа, боодолд хийж тусгай цэгт хаяна
- Хог хаягдлыг ангилан ялгалт хийж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ялгах
- Хог хаягдлаас үүсч болох элдэв төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх
- Ахуйн хэрэгцээнээс гарах бохир шингэнийг аюулгүй горимын дагуу тээвэрлэж, хадгалах
- Шингэн хаягдлыг уурхайн ажилчдын эрүүл мэндэд хор нөлөө учруулахгүйгээр хол зайд байрлуулах

- Хөрсөнд нэвчихгүй байх арга хэмжээг авах

Хүснэгт №. 9 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Зарцуулагдах зардал мян.төг	Шалгуур үзүүлэлт
			2025 он	
1	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ. /Сонгинохайрхан дүүрэгийн ТҮК/	Компанийн захирал	1000	Гэрээ байна.
2	Хог хаягдлын төлбөрөө төлнө.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Төлбөр төлсөн баримт байна.
3	Хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож Сонгинохайран дүүрэгт сар тутамд мэдээллэж байна.	Уурхайн дарга	-	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
4	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх		250	Мэргэжлийн халдваргүйжүүлэх газраар
5	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал		250	Жил бүр
Нийт зардал мян.төг		1 500.0		

IV.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Эмээлт уул” барилгын чулууны ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж хэмжих, шинжлэх арга стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх болон үр дүнг хянах ажлыг “Билэгт гүнж” ХХК-ийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдана.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11 сард багтааж сум, аймгийн төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулах.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон түүний хэрэгжилтийг хянах субъектүүд ажил, үүрэг: Байгаль орчны мэргэжилтэн дараах ажлыг гардан зохион байгуулна.

- Төсөл хэрэгжүүлэгчийн жилийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэгчтэй холбогдсон зардлыг тусган батлуулсан байх,
- Төслийн талбайн ойр орчмын цэгүүдээс дээжийг тогтоосон хугацаанд нь мэргэжлийн байгууллагуудаар авуулж, лабораторийн шинжилгээ хийлгүүлэх,

- Орчны хяналт шинжилгээний ажлыг байгаль орчны шинжилгээний төв лаборатори зэрэг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн гүйцэтгэх ба түүнд зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах,
- Шинжилгээний үр дүнг суурь үзүүлэлттэй жишин үзэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай, шийдвэрийн төсөл боловсруулах
- ИТХ, түүний тэргүүлэгчдэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнуулах, шаардлагатай шийдвэр гаргуулах арга хэмжээ авуулж, гүйцэтгэлийг хянах

Төсөл хэрэгжүүлэгч дараах асуудлыг хариуцна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг жил бүрийн төсөвт тусган саадгүй төлөх,
- Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулж тухайн орон нутгийн Иргэдийн нийтийн Хурал, түүний тэргүүлэгчдийн гаргасан шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хяналт шинжилгээний үр дүнг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн гаргаж, Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчид ба БОУАӨЯ-нд тайлагнаж байх,
- Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгтийн загварыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар болон хяналт шинжилгээ хийсэн мэргэжлийн байгууллагаас авах.

Хүснэгт №. 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил		Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг		Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин							
Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО ₂ , хүчил НСО ₃ , кальци Са, хлор Cl, кали К, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор В, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Мо, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силикон Si, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактерилогийн бүрэн шинжилгээ.	-Унд ахуйн хэрэглээнд ашиглах худагт		Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Усны ерөнхий химийн шинжилгээ 30.0 мян.төг, Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 40.0 мян.төг, Хими бактерилогийн бүрэн шинжилгээний үнэ 70.0 мян.төг 1 жилд 2 удаа буюу нийт 140.0 мян.төг		(70+70.0)*2*1 жил= 280.0 мян.төг	-MNS 0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ -Усны чанар хаягдал бохир ус MNS 4943:2000
Хөрсний төлөв байдал, бохирдолт							
Нефть, нефтийн бүтээгдэхүүн, Хар тугалга, Азот, Фосфор, Усан мандал, Кальци, Магни, Кали, Магни, Хлор, Сульфат, Карбонат, Гидрокарбонат, Ариун цэврийн тоо,	Мониторингийн цэгүүдээс		Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 30.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 40.0		70 *2*1 жилд = 140 мян.төг	-MNS 5850:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Коли-титр, Перфрингес-титр				мян.төг 1 жилд 140.0			
Агаарын чанар							
-Тоосжилт (PM10, PSM, PM25) - Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын давхар исэл, Аммиак г.м	- Мониторингийн цэгүүдээс:		Жил бүр 2 удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь.	24 цагийн хэмжилт хийж (O2, SO2, NO2, CO , цаг агаарын үзүүлэлт)-ийн хамт тооцоход 250.0 мян.төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А- 342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов. 1 жилд 500.0		250.0 төг*2*1 жилд 500.0 мян.төг	-ISO 9001:2000 MNS0017.2.5.12:88 Хүхэрлэг хий-SO2 шинжлэх ТХМ буюу аэрозолины арга -MNS0017.2.5.11-88 Азотын давхар исэл
Ургамал							
-Хяналт шинжилгээ хийх талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлно.	Мониторингийн цэгүүдээс: 108°49'12,54" 46°1'57,28" 108°49'42,77" 46°1'16,13"		жилд 1 удаа	Мэргэжлийн шинжээч хөлслөх, 800.0 мян. төг		800 *1 жил = 800.0 мян.төг	-Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох
Нийт дүн						1720.0 мян.төг	

IV.9. Байгалийн гамшгаас үүсэж болзошгүй ослын менежментийн төлөвлөгөө

Газар хөдлөлт: Төсөл хэрэгжих район нь 7 баллын газар хөдлөлийн бүсэд багтдаг. Газар хөдлөл нь байгалийн гамшгийн хамгийн аюултай хэлбэрийн нэг бөгөөд газар хөдлөлийг урьдчилан тогтоож, мэдээлэх боломж муу.

Салхи, шуурга: Хавар, намрын улиралд, ялангуяа хаврын улиралд үе үе хүчтэй салхитай байдаг бөгөөд салхины хамгийн их хурд 28 м/сек-ээс хэтрэх тохиолдол тус бүс нутагт олонтоо тохиолддог. Хавар, намрын саруудад салхины хурд хамгийн их байдаг.

Салхи шуурганы хүчтэй нөлөөлөл үүсэх нөхцөлтэй тул бүтээгдэхүүнийг тээвэрлэх, шатах тослох материалын агуулахыг байршуулах, үйлдвэрлэл явуулахдаа тогтмол цаг уурын мэдээ сонсож дээрх нөлөөллийг сайтар харгалзан үйл ажиллагааг явуулна.

Үер: Уурхайн район нь олон жилд цөөн удаа тохиолдох үерийн аюулд бага өртөнө. Зуны хур борооны үед цаг агаарын нөхцөлөөс хамааран үерийн аюул ажиглагдах нөхцөлтэй тул уурхайд үерийн ус зайлуулах далан байгуулна.

Аянга цахилгаан: Зуны улиралд, ялангуяа хур бороо элбэгтэй 7, 8 дугаар саруудад аянга цахилгааны үзэгдэл илүүтэй тохиолдоно. Зуны улиралд 20 орчим өдөр аянга цахилгаан буудаг, 1.0 км² талбайд 4-6 удаа ниргэлт болдог нь үйлдвэрийн болон уурхайн техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл учруулж, улмаар аюул осол тохиолдож болох магадлалтай.

БҮЛЭГ V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана. “Билэгт гүнж ” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Компаний удирдлага
2. ХАБЭА-н инженер

Эдгээр 2 хэсгийн хэрэгжүүлэхү үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайланг орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, болон нутгийн иргэд, ТББ хянаж оролцож байхаар тусгав. Зардлыг тухайн үеийн төлөвлөгөөт зардлаар тооцно.

Хүснэгт№. 11 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал

№	Арга хэмжээ	Хугацаа	Давтамж
II-1	Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).	2026	Байнгын
II-2	Байгаль орчны бодлого, зорилго, зорилт, хууль эрхзүйн болон бусад шаардлагуудын дагуу үйл явцыг хянаж хэмжих ба үр дүнг тайлагнах	2026	Жил бүр
II-3	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр
II-4	Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компаний хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;	2026	Жил бүр
II-5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн явцын талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тайлагнах.	2026	Жил бүр
II-6	Төслөөс үүсч болзошгүй нөлөөллийг хамгийн бага байлгах буюу нөлөөлөлгүй байлгах үүднээс соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;	2026	-
II-7	Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг оролцогч талууд болон орон нутгийн удирдлагуудад мэдээлж байх;	2026	Жил бүр
II-8	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2026	-
II-9	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах, тэдний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг гэрээнд тусгах.	2026	Тухай бүрт нь